



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/160.

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.а, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.4, 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн Уянга суманд баригдах үерийн усны далан шуудууны байгууламжийн зураг төслийг хийж гүйцэтгэсэн “Хидро-Инженеринг” ХХК-д гэрээний үнийн дүнгийн 50 хувь болох 24,476,000 (хорин дөрвөн сая дөрвөн зуун далан зургаан мянга) төгрөг, Хархорин сумын халдвартын эмнэлгийн барилгын их засварын ажлын зураг төсөв боловсруулсан “Итгэлт-Өргөө” ХХК-д гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл болох 4,600,000 (дөрвөн сая зургаан зуун мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх зардлыг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100346